



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/44

Чингис хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", 29.3, Засгийн газрын 2008 оны "Сургалт, семинарын зохион байгуулалтыг сайжруулах тухай" 32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нутгийн захиргааны байгууллагын харьяа байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч, албан хаагч нарын албан томилолтоор ажиллах, үр дүнг тайлагнах журмыг нэгдүгээр, албан томилолтын загвар болон удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан өөрийн сум, харьяа байгууллагын ажилтан, албан хаагчдын сургалт, семинарт оролцох асуудлыг цэгцэлж, томилолтын үр дүнг тогтмол дүгнэж ажиллахыг сумдын Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагын харьяа байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/245, 2019 оны А/50 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010124

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ХАРЬЯА
БАЙГУУЛЛАГУУДЫН ДАРГА, ЗАХИРАЛ, ЭРХЛЭГЧ, АЛБАН ХААГЧ НАРЫН
АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ, ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нутгийн захиргааны байгууллагын харьяа байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч, албан хаагч нарын албан томилолтоор ажиллах ажлыг журамлах, тэдгээрийн томилолтын тайлан, үр дүнг дүгнэхэд энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Томилолт олгох удирдлагын тогтолцоо

2.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга дараах төрийн албан хаагчдад албан томилолт олгоно:

2.1.1. Аймгийн Засаг даргын орлогч

2.1.2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар, мэргэжилтэн

2.1.3. Сумын Засаг дарга /албан томилолтоор ажиллах удирдамж батална/

2.1.4. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагийн болон аймгийн Засаг даргын томилдог төрийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нар

2.1.5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын эзгүйд Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга томилолт олгож болно.

2.2. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагийн болон аймгийн Засаг даргын томилдог төрийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нар харьяа хэлтсийн даргад удирдамжийг танилцуулж гарын үсэг зуруулсаны дараа аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар албан томилолтыг баталгаажуулж Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан мэргэжилтэнд бүртгүүлж тамга даруулна.

2.3. Сумдын Засаг дарга нар аймгийн нутаг дэвсгэрээс өөр газарт албан томилолтоор ажиллахдаа 2 дугаар хавсралтаар батлагдсан удирдамжийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Нутгийн захиргааны бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэнд цахимаар ирүүлж Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга танилцаж гарын үсэг зурж аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар баталгаажуулж цахимаар буцааж хүргүүлсэний дараа албан томилолтоор ажиллах эрх үүснэ.

Гурав. Томилолтоор ажиллах, үр дүнг тайлагнахад баримтлах зарчим

3.1. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт төрийн албан хаагч томилолтоор ажиллахад томилолтын зардлыг урьдчилан олгоно.

3.2. Томилолтоор ажиллах үед ажлын зайлшгүй шаардлагаар хугацааг сунгах бол энэ тухайгаа томилолт олгосон удирдлагад мэдэгдэж хугацааг сунгаж болно.

3.3. Төрийн албан хаагч нь баталсан удирдамжийн дагуу томилолтоор ажиллах бөгөөд томилолтоор ажилласан тухай илтгэх хуудсыг томилолт олгосон удирдлагад ажлын 3 өдрийн дотор илтгэнэ.

Томилсон удирдлага буюу аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, түүний эзгүйд Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн дарга тус тус гүйцэтгэлийг баталгаажуулж болно.

3.4. Томилолтын зардлыг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж байгаа Сангийн сайдын баталсан хэмжээ, нормативаар бодож олгоно.

Дөрөв. Хориглох зүйл, хүлээх хариуцлага

4.1. Нутгийн захиргааны байгууллагын харьяа байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч, албан хаагч нар эрх бүхий албан тушаалтны томилолтгүй албан ажлаар зорчихыг хориглоно.

4.2. Төрийн албан хаагч нь энэ журмын 3.3 дахь заалтын дагуу томилолтын тайланг илтгээгүй тохиолдолд эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэлд гарын үсэг зурж түүнд томилолтын зардал олгох эрхийг нээхгүй байх үүрэгтэй.

4.3. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагийн дарга нар аймгийн Засаг даргын Тамгын газартай зөвшилцөөгүй сургалт, семинарт сумдаас төрийн албан хаагч оролцуулахыг хориглоно.

Аймгийн Засаг даргын 2021 оны
..... дугаар сарын.....өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ТОМИЛОЛТООР АЖИЛЛАСАН ТУХАЙ ИЛТГЭХ ХУУДАС

1. Ажилласан хүн:
2. Ажилласан хугацаа:
3. Хийгдсэн ажил:
4.

Холбогдох зураг, тэмдэглэл, баримтуудыг хавсаргах
/Хавсралт хуудас/

Илтгэх хуудас бичсэн:

Гарын үсэг _____ нэр _____

Танилцсан:

Гарын үсэг _____ нэр

ХЭНТИЙ АЙМАГ



АЛБАН ТОМИЛОЛТ

№

Албан тушаал:

Эцэг /эх/-ийн нэр:

Нэр:

Албан ажлаар _____ руу оны _____ сарын _____ -ны өдрөөс
хоногийн хугацаагаар олгов.

ДАРГА

Ж.ГАНБААТАР

Албан томилолтоор ажиллах удирдамж

Сургалт, семинарын сэдэв:

.....

Томилолтоор ажиллах газар:

.....

Зардал /томилолтоор ажиллахад шаардагдах зардал хаанаас
гарч байгааг бичнэ/

.....

Зорилго:

.....

.....

Удирдамж бичсэн:/...../

Танилцсан:/...../
Хэлтсийн даргын нэр Гарын үсэг

Ажилласан газрын нэр	Ирсэн	Буцсан	Гарын үсэг

Санхүү-д

.....нь үүрэгт ажлаа бүрэн хагас
биелүүлсэн /зур/ тул.....хоногоор бодож томилолтын
зардлыг.....хувиар олгоё.

Дарга:.....

Тооцоо

.....

.....

.....төгрөг
авлаа.

Ня-бо:

.....овогтой...../...../

Томилолтоор ажилласан:

.....овогтой...../...../